

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 03 дүгээр сарын 29-ний өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-20
<hr/>	
1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	9-16
2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	16
3. “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	16-20

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 53 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяа, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Э.Батшугар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Г.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Ц.Туваан, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Жавхлан, Б.Жаргалмаа, Г.Занданшатар, Ц.Идэрбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Д.Батлут, С.Одонтуяа, Ш.Раднаасэд;

Тасалсан: А.Адьяасүрэн, С.Амарсайхан, Г.Ганболд, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар;

Хоцорсон: Г.Амартүвшин -1 цаг 02 минут, С.Ганбаатар -02 минут, Т.Доржханд -36 минут, С.Чинзориг -59 минут, Б.Чойжилсүрэн -32 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Чинбүрэн, О.Цогтгэрэл нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Чинбүрэн, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Олон улсын эмч нарын өдөр”-ийг тохиолдуулан эмч, эмнэлгийн ажилтнуудад Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “PISA-2022” үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн талаар хийх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, мэдээллийг хойшлуулав.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Завсарлагатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./11:14/

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Энх-Амгалан, Б.Баттөмөр нар дэмжиж үг хэлэв.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Ганбат нар эсрэг байр суурьтай үг хэлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал тул санал хураалтад оролцохгүй тухай мэдэгдэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 12  
Бүгд: 37  
67.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./11:59/

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 11  
Бүгд: 37  
70.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулав.

Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

**Л.Мөнхбаатар:** “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 14  
Бүгд: 38  
63.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 1 цаг 21 минут үргэлжилж, 72 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 14 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 53 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданишатар:** Улсын Их Хурлын гишүүд суудлаа эзэлье. Улсын Их Хурлын гишүүдийн амрыг эрье. Ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэнэ. Эхэнд нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх нь үргэлжилнэ. 2-т, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх мөн үргэлжилнэ. 3-д Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ. Үдээс хойших нэгдсэн хуралдаан, Ерөнхий сайдын мэдээлэл, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA 2022 үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн талаар хэлэлцэнэ. Эдгээр асуудлуудыг өнөөдөр хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх,

асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Одонгийн Цогтгэрэл нараас албан бичгүүд ирүүлсэн байна. Үүнийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танаа Монгол Улсын Их Хурлын 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг гэсэн байна. Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танаа миний бие 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн гэсэн байна. Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх саналаа үгээр хүргүүлж байна. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл гэсэн байна. 3 гишүүн хүсэлт ирүүлсэн байна. Одоо Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг үг хэлье.

**Н.Алтанхуяг:** Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Би энэ манай Их Хурал дээр яригдаж байгаа Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, энэ Цэцэд маргаан шийдвэрлэх хуультай холбоотой санал хэлэх гэж байгаа юм. Чиний нэр тэр дотор байлаа шүү дээ, чи юугаа ярих гэж байгаа юм гэж асууж магадгүй байх. Би уг нь анх энэ ажлын хэсэгт нь бас орж ажиллала гэсэн юм. Юу гэхлээр Үндсэн хуулийн цэц маань өөрөө энэ иргэний үндсэн эрхийн маргааныг шийдэх асуудлыг шийддэг болно гэж энэ бол том



концепц ингээж гарч ирсэн учраас би энд орж ажиллая гэсэн юм. Тэгээд явсан чинь жаахан хурдтай явуулаад, ерөөсөө олигтой хэлэлцэхгүйгээр ингээд л Их Хурал руу орчихлоо л доо. Тийм учраас би гарын үсэг зураагүй. Тэгээд Мөнх-Оргил, Бямбацогт 2 гарын үсэг зураад, энэ 7, 8 гишүүнээс 2 нөхөр ингээд гарын үсэг зурж ороод одоо хэлэлцээд байгаа юм.

Одоо би нэг ёр шиг нэг юм хэлчихмээр байх юм. Та нар анхаараарай. Ийм морин дэл дээгүүр орон гаран сонгуулийн сураг дуулдсан бүгдээрээ мориндоо мордоод давхичихсан ийм цаг үед ийм концепцын шинжтэй том хууль хэлэлцэх бол их аваартай, осолтой байдаг. Өмнө нь прокурорын дэргэдэх мөрдөн гэдэг мөрдөнг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэх тухай хуулийн төслийг бол Засгийн газар санаачлаагүй, намайг Ерөнхий сайд байхад манай бас нэг 10-аад гишүүн санаачлаад, 2 намын хамтарсан 10-аад гишүүн санаачлаад орж ирээд энд нь ерөөсөө ингээж маш хурдтайгаар явуулаад л тэгээд Прокурорын дэргэдэх мөрдөнг алга болгочихсон. Энэнээс хойш энэ хууль хяналтын байгууллагуудын хүний эрх зөрчиж байгаа энэ новшнуудад ерөөсөө тооцдог хариуцлага гэдэг юм байхгүй болчихсон шүү дээ. Тэгээд одоо хүртэл тэр хууль засагдаагүй, засаагүй. Би Ерөнхий сайдаа өгчхөөд тэр хуулийг засъя гэж оруулсан чинь унагаагаад хаячихсан. Унагаагаагүй л дээ Их Хурлын дарга нь ингээд ширээнийхээ доогуур хийчихдэг байхгүй юу. Ямар хуулийг явуулах вэ, ямар хуулийг явуулахгүй вэ гэдгийг ингээд ишийдээд. Ийм юм руу явчих вий дээ.

Тэгээд би энэ Мөнх-Оргил гишүүнтэй гээд сая ярилаа л даа. Юу нь болохгүй байгаа юм гээд надаас тэгээд байгаа юм. Би хоёр, нэг юмыг нь хэлье дээ бас, минут нь хаана явж байгаа вэ. Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ, энэ их аюултай Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ гэдэг лугаа. Хэн нэгэн дургүй хүргэсэн амьтныг нь болбол бүрэн эрхийг нь түр түдгэлзүүлж байгаад юм

уу, тэр хооронд нь нөгөө нэг хулгай элдвийнхээ дээрмийнхээ юмыг хийчих боломж гарч ирэх вий. Үндсэн хуульд болбол түдгэлзүүлэх тухай ойлголт ерөөсөө байхгүй. Харин эгүүлэн татаж болно. Дараа нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дээр гарах гээд байна энд байгаа заалтаар. Угтаа Цэцийн ямар нэгэн гишүүн хууль зөрчсөн байх юм болбол тэрнийг эгүүлэн татах асуудлыг Улсын Их Хурал ярих ёстой. Гэтэл энэ хууль дээр юу гэж биччихээд байгаа вэ гэхээр Улсын Их Хурал тэр гишүүний асуудлыг Цэцэд нь өгнө гэнэ үү? Ийм юм байж болохгүй. Үндсэн хуулийн цэцийн дээр зөвхөн Үндсэн хууль л байна. Үндсэн хуулийг л сахин мөрдүүлэх үүрэгтэй. Түүнээс биш одоо бид нар нэг гоё юм хийгээд байгаа шүү дээ. Манай Их Хурал дээрээс нэг баахан хүнийг л сонсгол хийгээд л, наана цаана гэдэг. Цэцийн гишүүнийг ч тэгж тавьж байгаа шүү дээ. Тэгээд тэрнийг татах тухай асуудлыг бид нар оруулдаг юм ерөөсөө тийм байж болохгүй. Энэ бол Үндсэн хуулийн цэцийн гишүүний бие даасан байдал болбол асар том халдлага хийж байгаа гэж би харж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн хэн ч болж болохуйцаар тийм заалт орчихжээ гэж би бас хэлж байгаа юм. Үндсэн хууль дээр ийм байдаг байхгүй юу. Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй л гэж байдаг юм. Гэтэл энэний урд тал дээр хуулийн дээд боловсролтой гээд биччихээд байгаа юм. Дараа нь энэ 2-ыг нь уншихгүйгээр хуулийн дээд боловсролтой хүнийг 40 нас хүрэхээр нь Цэцийн гишүүнээр томилж болно гээд л хийнэ. Тэгэхээр энэ бол суларчхаж байгаа юм. Тэгэхээр Цэцийн гишүүн ийм сул хүн байж болохгүй. Ийм, ийм зүйл байгаа.

Дээр нь энэ Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно гэж Үндсэн хуулийн цэц дээр бичсэн юм. Ийм, ийм зүйл байна. Та нар нэг анхаарчхаач. Одоо энэ сонгууль гээд. Эсвэл энэ хуулийг одоо ярихаа

больчихмоор байна. Ер нь бол зарчмын хувьд нэг чухал юм ярих гээд байгаа юм Мөнх-Оргил гишүүн. Тэр нь бол иргэний үндсэн эрхийн маргааныг Цэц шийддэг больё гэдэг бол том концепцын бүр чухал асуудал. Энэний чинь одоо ингэж орж гараад морь малаа унаж давхиад, машин тэргээ унаж давхиж байгаад ярина гэвэл ална шүү. Тэгээд нэг гарчихсан хуулийг дараа нь өөрчлөх гэхээр мянган тээг тавьдаг юм байна лээ. Энийг анхаарч шийдэж өгөөч гэж би хэлж байгаа юм. Би Мөнх-Оргил гишүүнтэйгээ сая бас нэлээн ярьсан л даа. Тэгээд дахиад нэг юм хэлчихье. Харин одоо энэ Их Хурал юу яримаар байна вэ гэхээр Ардын намын мөрийн хөтөлбөр 70, 80 хувьтай биелчихсэн гээд байна. Тэрнийг энэ Их Хурал дээр харин хэдүүлээ нэг ард иргэдийнхээ өмнө нэг жаахан.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн үг хэлье.

**Ж.Чинбүрэн:** Их Хурлын гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Маскаа тайлж, ажлаас хаширалгүй нэг ч асуудал гаргаагүй эрүүл мэндийн салбарынхандаа бас нийт парламентын гишүүд, чуулганыхаа нэрийн өмнөөс бас баярлалаа гэдэг энэ үгийг хэлмээр байна. Өнөөдөр бас дэлхий нийтээрээ эмч нартаа бас баярлалаа гэж хэлдэг ийм өдөр тохиож байгаа. Та бүхэн бид энэ удаагийн парламентаар бас ковид цар тахлыг бараг 40 мянга гаруй иргэдээ эрсдэлээс хамгаалж чадсан шийдвэрүүдийг гаргаж чадсан ийм парламент. Манай парламентын гишүүд улс төржилгүй, нам болон хуваалцалгүй эрүүл мэндийн асуудлыг бүгдээрээ нэг цонхоор харж, нэг хүслээр дэмжиж өгсөн явдлын нэг том илэрхийлэл бол бид олон, олон эрүүл мэндийн салбарын реформуудын хууль баталж чадсан. Тухайлбал санхүүжилтийн асуудлыг 20 оны 8 сарын 29-нд баталснаараа бид яаралтай тусламж, эд эс, эрхтэн шилжүүлэн суулгах, хорт хавдрын тусламж үйлчилгээг төрийн үйлчилгээнд

хамруулж, ард иргэдээ санхүүгийн дарамтгүй үзүүлж чадсан ийм парламент. Бид төвөгтэй олгодог байсан эмийн хөнгөлөлтийг хөнгөлөлттэй олгодог, төсөв санхүүг нь нэмж, ард иргэдээ бас эмийн дарамтад орохгүй байх энэ боломжийг олгож чадсан ийм парламент.

Манай парламентын бас нэг том баталсан зүйл бол өвчнийг араас нь биш, урьдчилж урьдчилан сэргийлдэг энэ тогтолцоог хийхийн тулд эрт илрүүлийг хүртэл хийж чадсан, төсөв тавьж чадсан, Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуулийг баталж чадсан, хавдрын өвчний шалтгаан болж байгаа тэр вирусийн эсрэг вакцинжуулалтын хуульдаа хүртэл оруулж чадсан ийм парламент ажиллаж байгаа. Өнөөдөр бид бас Эмийн үнийн өсөлтийн учир шалтгааныг судлах түр хороо ажиллуулж, эрүүл мэндийн салбарын санхүүгийн дарамт болж байгаа чанаргүй эм, үнийн өсөлттэй бас тэмцэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа ийм парламент. Тийм учраас би бас энэ парламентын энэ том бүрэлдэхүүнээрээ бид эрүүл мэндийн салбарыг том шинэчлэлийг хийж чадсан парламентчдадаа бас нийт эмч, эмнэлгийн ажилчдынхаа өмнөөс бас баярлалаа гэж та бүхэндээ бас хэлмээр байгаа юм.

Дараагийн чухал асуудал бол бид бас энэ Эмийн өсөлттэй холбоотой түр хорооны сонсголыг хийхээс өмнө ер нь явцын талаар чуулганыхаа чуулган дээр бас сонсох ийм саналыг бас Мөнхбаатар дарга танд хэлэх гэсэн юм. Тэгээд ийм сонсгол хийх боломж бас олгож өгөхийг хүсье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Чинбүрэн гишүүндээ баярлалаа. Өнөөдөр Олон улсын эмч нарын баярын өдөр тохиож байна. Ард иргэдийнхээ эрүүл мэндийн манаанд зогсож, өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол Улсын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа эмч, эмнэлгийн ажилтан,



албан хаагчдадаа Улсын Их Хурлын нэрийн өмнөөс баяр хүргэе. Манай парламентад бас эмч нарын төлөөлөл байгаа. Монгол Улсын хүний гавьяат эмч Жигжидсүрэнгийн Чинбүрэн, хүний гавьяат эмч Буланы Бейсен, Цэвэгдоржийн Тува нартаа бас эмч нарын баярын мэндийг өргөн дэвшүүлбэ. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ долоо хоногийн үдээс хойших чуулган дээр Ерөнхий сайдын мэдээлэл байсан, бас цуцлагдаж байгаа юм байна. 2 долоо хоног, хоногийн өмнө байсан Ерөнхий сайдын мэдээлэл бас цуцлагдсан. Тэр тусмаа Ерөнхий сайд энэ Их Хурал дээр орж ирж, мэдээлэл хийхээ больсон. Салбарын сайд нь мэдээлэл хийнэ гэдэг. Салбарын сайд нь дураараа, дураараа би томилолттой, орон нутгийн томилолттой, гадаад томилолттой гээд л нэг бичиг өгөөд л Улсын Их Хурал дээр хойшлуулчихдаг.

Улсын Их Хурлын дэд дарга энэ Улсын Их Хурлын дэг болоод энэ хуулиараа ийм боломжууд байдаг юм уу? Энэ чинь одоо гүйцэтгэх засаглал нь парламентынхаа дээр байна уу, яг юу болоод байна вэ? Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийнэ, энийг зөвхөн сөрөг хүчний гишүүд асууна гэдэг чинь бас энэ ард түмний мэдэх эрхийг, тэр тусмаа өнөөдөр парламентад байгаа олонх чинь ард түмний 40 хувийн л санал авсан олонх, цаана нь 60 хувь та бүгдийг дэмжээгүй 60 хувь байгаа. Тэгээд олонхоос бусад нь асуух ард иргэдийн энэ санал асуултыг ингээд дураараа өөрчилдөг, Ерөнхий сайд нь орж ирдэггүй, салбарын сайд нь зүгээр л би орон нутгийн томилолттой, олон улсын томилолттой байна гээд л бичиг өгөөд хаачихдаг. Энэ нэг ийм завхарсан зүйлийг дараа, дараа энийг, энэ нэг арга хэмжээ авмаар байна Улсын Их Хурал. Энэ чинь одоо яг юу гэсэн үг вэ? Энэ чуулган эхлээд 2 дахь Ерөнхий сайдын мэдээлэл ингээд л дураараа хойшлогдож байна.

Дахиад дээрээс нь энэ долоо хоногт орж ирж байгаа Ерөнхий сайдын мэдээллийн агуулга нь тэр PISA буюу дунд сургуулийн 15 настнуудын 9 дүгээр ангийнхны олон улсын үнэлгээг танилцуулах ийм явдал байсан. Энэ олон улсын үнэлгээ дээр тийм санаа зовних олон зүйлүүд энэ олон улсын манай боловсролын тогтолцоог үнэлсэн үнэлгээ байсан. Та бүхэнд ингээд сонирхуулаад хэлэхэд энэ жишээ нь 9 дүгээр ангийн хүүхэд 15 настай Монгол хүүхэд, Монгол хүүхдийн 3 хүн тутмын 3 хүүхэд тутмын 2 нь Монголоороо уншаад, уншсаныгаа ойлгохгүй байна гэж олон улсын үнэлгээ гарч байна. Монгол хүүхдийн 3 хүүхэд тутмын 2 нь Монголоороо уншаад ойлгохгүй байна. Монгол хүүхдүүдийн 2 хүүхэд тутмын нэг нь математикийн анхан шатын үйлдлүүдийг 9 дүгээр ангийн хүүхэд хийж чадахгүй байна, олон улстай харьцуулахад танай Монголын бол дунд боловсролын тогтолцоо, суурь боловсролын тогтолцоо чинь гүн хямралд оржээ гэж Олон улсын байгууллага Монголыг үнэлсэн үнэлгээг өнөөдөр хэлэлцэх ёстой байсан. Одоо 2 дахиа ингээд хойшлуулж байна. Үнэхээр томилолттой байдаг юм уу, аль эсвэл энэнээсээ зугтдаг юм уу? Үнэхээр ийм сэтгэл зовним ийм. 7000 хүүхдээс судалгаа авснаас Монгол хүүхдүүдэд тэр топ түвшний үнэлгээнд Монголоос нэг ч хүүхэд тэнцээгүй гэсэн үнэлгээ олон улсын нэг ч хүүхэд тэнцээгүй. Маш олон, олон зүйлүүд энэ дээр бий.

Монгол Улс дунджаар нэг хүүхдэдээ 12 мянган долларын зардал гаргадаг юм байна суурь боловсрол олгоход. Яг энэ хэдийгээр их мөнгө биш ч гэсэн яг ийм зардал гаргаж байгаа улс орнууд Монголоос Вьетнам зэрэг орнууд Монголоос илүү өндөр үр дүнд хүрчихжээ. Танай Монголын суурь боловсролын тогтолцоо чинь үнэхээр гүн хямралд орсон гэдэг энэ үнэлгээг дахиад тэр ЮНЕСКО-н байгууллагын 19 оны дүгнэлт ч энэ дотор явж байгаа. Үнэхээр энэ дээр сэтгэл зовнисон ийм, ийм олон, олон зүйлүүд байдаг. Тэгээд дураараа Ерөнхий сайд нь салбарын сайдаа мэдээлэл хий

гэдэг, салбарын сайд нь би томилолттой гээд одоо 2, 3 удаа дураараа нэг бичиг шидээд шийддэг. Энийг нь Улсын Их Хурал зүгээр хүлээж аваад л тэнд хойшлууллаа гээд л алх цохиод сууж байдаг. Энэ чинь уг нь болбол парламент, дахиад дээрээс нь цөөнхийн асуулт асуух ёстой бараг Улсын Их Хурал дээр байгаа ганц цаг. Энийг нь ингээд Улсын Их Хурлын Монголын парламентын 40 хувийн мандаттай улс төрийн хүч нь ингээд дураараа хойшлуулаад, өөр өөрийн үзэмжээр асуудал шийдээд байгаа нь үнэхээр харамсалтай байна. Тэгэхээр энэ Улсын Их Хурлыг удирдаж байгаа дарга, дэд дарга нар энэ дэг зөрчигдөөд байгаа, үзэл санаа зөрчигдөөд байгаа энэ асуудал дээр цаашид анхаарч, хариуцлагатай хандмаар байна.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд үг хэллээ. Норовын Алтанхуяг гишүүний тавьсан асуудал байна. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, мөн Цэцэд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан үг хэлсэн. Өнөөдөр бол хэлэлцэх эсэх нь одоо үргэлжлээд явж байгаа. Үүн дээр бас та байр сууриа илэрхийлж үг хэлэх боломжтой. Ингээд хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа бол одоо ажлын хэсэг гараад ингээд явна. Энэ ажлын хэсэг дээр бол илүү нарийвчлаад ярих ийм боломжууд нь байгаа гэж би бодож байна.

Цогтгэрэл гишүүний тавьсан асуудалтай холбогдуулан бас үг хэлье гэж бодож байна. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас албан бичиг ирүүлсэн байна. Улсын Их Хурлын дарга Занданшатар танаа гээд бичиг ирүүлсэн байна. Үүнийг би танилцуулъя. Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан гадаадад томилолтоор ажиллаж байгаа тул Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх

олон улсын PISA 2022 үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийн товгыг хойшлуулж өгөхийг хүсье. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан гэсэн байна. Ингээд энд хойшлуулах албан бичиг ирсэн учраас уг асуудлыг хойшлуулж байна. Гэхдээ Цогтгэрэл гишүүний бас хэлж байгаа зүйл бас тодорхой үндэслэлтэй байгаа. Сөрөг хүчний зүгээс парламентын мэтгэлцээний одоо нэг гол чиглэл нь бол бас энэ Ерөнхий сайдын мэдээлэл, түүнийг тойрч хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнөдөг. Үүн дээр нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газар бол хүндэтгэлтэй хандах нь зүйтэй гэдгийг анхааруулан хэлье. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Гишүүд үг хэлж дууслаа.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье. Уг асуудлаар 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл ажлын 5 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан та үг хэлэх үү, болчихсон уу? Одонгийн Цогтгэрэл гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Энэ Үндсэн хуулийн цэцийн асуудлаар Ардчилсан намын бүлгийн зүгээс завсарлага авсан. Тэгээд өнгөрсөн бас хугацаанд хууль санаачлагчидтай бас ярилцсан. Тэгээд энэ дээр Ардчилсан намын бас өмнө нь парламентад ажиллаж байсан болоод одоо ажиллаж байгаа олон, олон гишүүд бас яг энэ асуудал дээр бас тодорхой

хэмжээний тийм эмзэглэсэн олон, олон байр сууриуд бас байгаад байгаа юм. Тэгээд хууль санаачлагч болбол бас тодорхой үндэслэл, олон зүйлүүдийг бас тайлбарласан энэ дээр. Ийм учраас ер нь энэ Ардчилсан намын бүлгийн зүгээс бас шийдвэр өмнөх хурлаар ч гаргасан байсан. Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ Үндсэн хуулийг хуулийн байгууллагыг байгууллагад өөрчлөлт оруулах энэ том хуулийн концепцын асуудалд Ардчилсан намын бүлэг энэ хуульд оролцох боломжгүй гэдэг шийдвэрийг гаргасныг би бас уламжилъя. Тэгээд олонх энэ асуудлаа хэлэлцээд одоо явах нь олонхын эрх мэдлийн асуудал.

**Л.Мөнхбаатар:** Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Цогтгэрэл дарга үг хэллээ. Завсарлагын хугацаа дууссан учраас хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Б.Энх-Амгалан, Тэмүүлэн, Баттөмөр, Норовын Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүн үг хэлье. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 одоо байр суурийг илэрхийлж үг хэлж болно.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг улс төрийн нам бол үл харгалзан дэмжих зайлшгүй шаардлага байгаа. Бид нар 1992 оны Үндсэн хуулиас хойших одоо 30 жилд тодорхой төрийн институт, эрх мэдлийн тэнцэл хуваарилалт, мөн тодорхой асуудлаарх алдаа оноогоо дэнсэлж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Дээр нь бас холбогдох салбарын хуулиудыг шинэчлэх шаардлага үүссэн байгаа. Тэгээд эрдэмтэд, манай Үндсэн хуулийн мэргэжилтнүүдийн бас нэлээд олон жил энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудлыг шинэчлэх шаардлага байна. Энэ тал дээр бас олон улсын зөвлөхүүд, олон улсын байгууллагууд, хүний эрхийн хуульчид гээд их олон хүмүүсийн судалгаа дүгнэлтүүд байгаа. Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн хуулийг илүү боловсронгуй болгох, Үндсэн хуулийн цэц маань яг одоо

хүний үндсэн эрхийн маргааныг хянан хэлэлцдэг буюу одоо Үндсэн хуулиар оногдуулсан Монголын иргэдийн үндсэн эрхийн баталгааг хангадаг гол механизм гэдгээрээ илүү чанаржиж, илүү шүүхийн статустай ажиллах ёстой. Тийм учраас бид нар бол энэ хуулийг бол дэмжин хэлэлцэх нь зүйтэй.

Тэгээд Ардчилсан намын зүгээс Цогтгэрэл гишүүний хэлсэнчлэн бас тодорхой асуудлаар хэт яарсан гэдэг юм уу, эсвэл сонгуультай холбоотойгоор энэ нэлээн нягталсан дүгнэлт хийхгүй их яаравчлан орж байна гэдэг болбол бас анхаарах нь зүйтэй. Тэгээд Их Хурлаар дэмжээд ажлын хэсэг гараад мөн ажлын хэсгийн зүгээс нэлээд олон тооны бас хэлэлцүүлэг, эрдэмтдийн болон улс төрийн нам эвслүүд, иргэний нийгмийн төлөөлөл, хэвлэл мэдээлэлтэй хамтарсан ийм хэлэлцүүлэг хийж, одоо энэ хууль дээр байгаа зарим нэг бас маргаантай, эсвэл бас тодорхой шүүмжлэлд орж байгаа энэ асуудлуудыг болбол илүү сайжруулах боломжтой байгаа.

Ер нь бол Үндсэн хуулийн цэц болбол яг Монголын Үндсэн хуулийн баталгаа, Монголын ардчиллын баталгаа гэдэг буюу олон улсын жишигээр энэ Үндсэн хуулийн шүүх гэдгээрээ орж ирэх энэ эрх зүйн боломжийг бол энэ төсөлд бол оруулж өгсөн байна. Энэ дээр бол Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд бас хүний эрхийн дэвшил гарч байгаа гэдгээр бол дэмжиж байна. Тэгээд манай гишүүд бас, бүлгүүд маань энэ дээр бас ойлголцож, нягтлан хэлэлцэх энэ боломжийг гаргаж өгөх нь зүйтэй байх.

**Л.Мөнхбаатар:** Мөнхцэцэг гишүүн дэмжсэн байр суурь илэрхийлж үг хэллээ. Одоо Улсын Их Хурлын гишүүн Дашидондогийн Ганбат үг хэлье. Ганбат гишүүний микрофоныг өгөөрэй. Нэгдсэн байна, үг хэлье.

**Д.Ганбат:** Байна уу? Тэр Мөнхцэцэг гээд л гараад байна л даа. Тийм. Тэр минут нь яваад байх юм.

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүний цагийг эхлүүлчихье, микрофоныг нь өгье.

**Д.Ганбат:** Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Энэ хуулийг Үндсэн хуулийн цэцтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн хуулийн шинэчилсэн энэ хуулийг бид нар ярьж байна. Тэгээд энэ дээр бол нэлээн нягт нямбай хэлэлцэж, 7 хэмжиж, 1 огтлох ийм л хууль л даа. Тэр хүний үндсэн эрхийг одоо Үндсэн хуулийн цэц дээр ярьдаг болъё гэдэг бол зөв зүйтэй асуудал. Энэ нь бол одоо бид бүхний бас ярих ёстой, батлах ёстой ийм асуудал. Гэхдээ одоо яг өнөөдөр ингэж түргэн түүхий ярьж арай боломгүй байна. Тэр тусмаа одоо эрх барьж байгаа намын хоёрхон гишүүн санаачлаад, тэгээд эрх баригчид дангаараа л батлах нь л дээ. Хэрэв батлах гэж байгаа бол. Тэгэхээр энэ чинь олон нийтийн, олон намын, энэ хууль тогтоогчдын бүгдийнх нь оролцоог хангасан тийм хоорондоо бас ойлголцсоны үндсэн дээр ингэж баталж явахгүй бол болохгүй хуулиудын нэг гэж үзэж байна. Энэ маягаар ингээд хүчиндээд ингээд явахад болохгүй.

Тэгээд энэ өргөн барьсан хуульд хамгийн наад захын шаардлага хангахгүй хэд хэдэн заалтууд байна. Тухайлбал, Үндсэн хуулийг өөрийг нь зөрчиж байгаа ийм заалт байна. Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн шүүгч нар бол Үндсэн хуулийн цэцийн гишүүн болж ажиллаж болохгүй гэсэн ийм заалт Үндсэн хуулийн 5 дээр байгаа юм л даа. Тэр зүй ёсны ийм Үндсэн хуулийн зүйл, заалт байгаа. Гэтэл тэр Үндсэн хуулийнхаа зүйл, заалтыг зөрчсөн ийм хууль өргөн барьчихсан яваад байгаа. Тэрийгээ тэгээд хууль тайлбарлах эрх бол Улсын дээд шүүхэд л байгаа. Үндсэн хуулийн талаар бол Үндсэн хуулийн цэц л ярих ёстой байх. Үндсэн хуулийн цэцэд ажиллаж байгаа манай Цэцийн гишүүд энэ Улсын дээд шүүх бол өнөөдөр бол энэ эрх баригчдын гар хөлийн үзүүрээр ажилладаг ийм л байгууллага болж хувирсан. Ийм үед бол тэд нараас санал

авсан гэдэг нэрийн дор энэ хуулийг ингээд баталж болохгүй болчихоод байгаа юм. Илүү сайн ярилцаж, илүү сайн нягталж, илүү сайн сайжруулж байж энэ хуулийг батлах ёстой. Тэгээд цаг хугацааны хувьд ч гэсэн хамгийн сүүлийн, удахгүй сонгуулийн өмнө болох гэж байгаа. Ялангуяа манай Алтанхуяг гишүүний хэлж байгаа энэ нөхцөл байдал бол бүрдчихсэн ийм үед бол энэ хуулийг ингэж ярилцаад батлах гээд ингээд улайран зүтгээд байгаа нь бол цаана нь болох бүтэхгүй юмнууд ингээд шургуулдаг. Бид бүхэн ярьдаг л даа. Тэгээд нэг их зүтгээд байдаг юмны цаана хувийн нэг жижигхэн эрх ашиг байдаг гэж. Тэр улс орон, ард түмнээ бодсон юм бол маш цөөхөн гарч байгаа. Тэр нь ч одоо ард түмний амьдралаар илэрч гарч байна. Тэгээд ийм нөхцөл байдалд, ийм парламент ийм цаг хугацаанд бол энэ хуулийг баталж болохгүй гэсэн байр суурийг Ардчилсан намын бүлэг ч гаргасан байгаа.

Энэ хуулийг санаачилсан нөхдүүд бол орж ирж бид бүхэнд бол бас энэ хуулийн талаар бол нэлээн ярьсан. Тэгээд гадуур, дотуур энэ хуульчид бол ярьж байна. Үнэхээр бас болохооргүй хууль оруулж ирчихсэн тэнд яриад байх юм. Тэгээд хуулиа ч тайлбарлаж байгаа нь Үндсэн хуулийг ч тайлбарлах эрхгүй хүмүүс өөртөө тийм эрх өгчихсөн, тэрийгээ тайлбарлаад л, ингээд л иймэрхүү маягтай ингэж улайран зүтгээд чичрээд байх шаардлагагүй юм. Энэ хуулийг нэлээн нягт нямбай, дараагийн олон парламентын төлөөлөл орж ирсэн, олон ард түмний төлөөллийн хангахуйцаар ийм парламент хэлэлцэх нь зүйтэй. Тэр тусмаа тэр энэ хуулийг өргөн барьж байгаа тэр заалтууд дотор Үндсэн хуулийн өөрийг нь зөрчихсөн ийм зүйл, заалттай ийм хуулийг ингээд бид нар ярилцаад, энийг батлах гээд ингээд сууж байгаа нь бол үнэхээр болохгүй зүйл. Эрх баригчид минь та нар маань тэртээ тэргүй муу нэртэй байгаа дээрээ ахиад бүүр муу муухай нэр зүүж яах нь вэ дээ гэсэн ийм зүйлийг бас хэлээд яриад, анхааруулчихъя. Ер нь байнга л хэлээд



яриад байгаа. Ер нь миний л зөв байдаг шүү дээ, тийм.

**Л.Мөнхбаатар:** Дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэллээ Ганбат гишүүн. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн үг хэлье. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 байр сууриа илэрхийлж үг хэлэх боломжтой байгаа шүү. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Би энэ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм. Энэ Монгол Улсын Бага Хурлаас 1992 оны 5 сарын 8-ны өдөр баталсан Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болбол Үндсэн түүхэн чиг үүргээ болбол гүйцэтгэчихсэн. Гэхдээ одоо болбол яг энэ Үндсэн хуулийн цэц гэдэг байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн үү, үгүй юү гэдэг ганихан ийм асуудлаар л шийдвэр гаргадаг болчих гээд байна. Зүй нь болбол Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 1.1.1.2-т Монгол Улсын хууль тогтоомжийг судалж, Үндсэн хуульд нийцүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гуйвалтгүй мөрдлөг болгож, хүний эрхийг зөрчиж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэц бусад бусад шүүхээс хяналт тавихыг нөлөөт, хяналт тавих хүчийг нөлөөтэй болгоно гэж. 1.1.3.1.3-д Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Үндсэн хуульд заасан хүний эрх зөрчигдсөн тохиолдлыг шийдвэрлэх онцгой үүрэгтэй ажиллуулах механизмыг бүрдүүлнэ гэж. 1.1.3.2.2-т, Хүний эрхийн үндэсний комисст Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний талаарх заалтыг зөрчсөн тухай асуудлаар иргэдээс гомдол

гаргахад тэднийг төлөөлөн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах, гаргаж шийдвэрлүүлэх эрх эдлүүлнэ гэж ингэж заасан юм. Тэгээд энэ асуудал 21 жил ерөөсөө яваагүй. Ингэж зорилтоо биелүүлээгүй, таг гацчихсан л ийм асуудал байхгүй юу.

Тийм учраас хүний үндсэн эрхийг зөрчигдөхөөс хамгаалж Үндсэн хуулийн цэц энэ дээр шийдвэр гаргаж, Үндсэн хуулийн цэцэд энэ хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдлөө гэдгийг одоо өгч байх нь болбол зүй ёсны асуудал байгаа юм. Энэ болбол бидний Үндсэн хуулиараа баталгаажуулсан хүнлэг, ардчилсан иргэний нийгэм байгуулах энэ асуудлын маань гол тулгуур багана нь юм байгаа юм. Монгол Ардын нам 30 дугаар Их хурлаараа бас энэ асуудлыг хүний эрхийн асуудлыг онцгойлон тавьж авч үзсэн. Тийм ч учраас хүний эрхийн хөтөлбөр, заалттай 300 гаруй, 300 гаруй хуульд одоо тусгайлан судалгаа хийж, тэр судалгаагаар 800 гаруй заалт Үндсэн хуулийг тодорхой хэмжээгээр зөрчиж байна гэж ийм дүгнэлт гарсан юм. Ийм учраас Үндсэн хуулийн цэцийг хүний эрхийн үндсэн асуудлыг хөнддөг ийм байгууллага байгаагаар гэж хүсэж байгаа учраас энэ асуудал явж байгаа юм. Яах вэ, дотор нь байгаа тэр нэг Их Хурал, Засгийн газрын гишүүд байсан хүмүүс Үндсэн хуулийн цэцэд очиж болохгүй гээд ингээд зам мөр нь хаагдчих вий гэж айж байгаа бол тэрийг нь тэгээд хэлэлцүүлгийнхээ явцад сольчихож болно шүү дээ.

Хамгийн үндсэн гол тулгуур маань энэ хүний эрх, эрх чөлөөний асуудал байхгүй юу. Сонгох, сонгогдох эрх, улс төрийн эрх, үгээ хэлэх эрх, хэвлэн нийтлэх эрх, жагсаж нэгдэх эрх, шударга шүүхээр шүүлгүүлэх эрх, энэ эрх чинь үндсэндээ болбол одоо ингээд хангагдахгүй байна гэдгийг бид нар энийг олон жил харлаа, 21 жил боллоо. Тэгээд энэ Үндсэн хуулийнхаа цэцэд энэ асуудлуудыг хэлж, шийдвэрлүүлдэг болохгүй болбол болохгүй байна л гэж үзэж байгаа юм. Хүнд, хүний суурь эрхийг л хөндөж болохгүй гэдэг.

Үнэхээр ардчилсан улс юм бол суурь эрхийг нь хөндөж болохгүй л гэсэн асуудал. Тийм учраас энийг болбол гишүүд маань бас дэмжиж явуулаад, тэгээд цаашид нь болбол энэ чинь тэгээд яах вэ тэр доторх заалтуудыг нь өөрчлөх юм болбол хэлэлцүүлгийнхээ явцад өөрчлөөд, саналууд гаргаад ингээд явчхаж болно гэж ингээж үзэж байгаа. Тийм учраас энэ асуудлыг би дэмжиж байгаа гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** 2 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Тийм болохоор бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлээд гишүүдээ танхимдаа оруулаарай. Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ.

**Б.Баттөмөр:** Энэ хуулийн төслийг бол дэмжиж байна. Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталсан. 92 онд Үндсэн хуулийн цэцийн хууль гэж батлагдсан. Энэ үеэс эхлээд Үндсэн хуулийн шүүхтэй болсон гэж ингээж үздэг. Өнгөрсөн хугацаанд 12 удаа өөрчлөлт орсон байдаг. Дорвитой томоохон өөрчлөлтүүд ороогүй. Манай Мөнх-Оргил гишүүн тэргүүтэй хүмүүс энэ дээр нэлээн их сайн судалгаа хийсэн, судалгааны баг авч ажиллуулсан юм байна лээ. Бас гадна, дотнын турширгуудыг нэлээн сайн судалсан юм байна лээ. Нэлээн их сайн өөрчлөлтүүд орсон гэж би харж байгаа энэ хуулийг тийм. Тэгээд энийг бол бид нар хэлэлцээд цаашаа явах нь зүйтэй. Энийг дараагийнх гэж хойшлуулаад байх ерөөсөө шаардлага болбол байхгүй. Өнөөдөр Монгол Улсад 830 гаруй хууль үйлчилж байгаа. Ер нь бол хуульчлах ёстой, эрх зүйн орчныг бий болгох ёстой асуудлуудыг үндсэндээ бид нар бол хийчихсэн байгаа. Хамгийн гол нь болбол өнөөдөр хэрэгжилт, тэр үйлчлэлийг л сайжруулах асуудал байгаа.

Нөгөө шатыг дээрээс нь цэвэрлэнэ гэж үг байдаг. Тэрэнтэй адилхан энэ Үндсэн хуулийнхаа эрх зүйн орчныг бүрдүүлэх, Цэцийн хуулиа эрх зүйн орчныг маш сайн бүрдүүлж өгөх нь болбол одоо үндсэндээ бүх асуудлын суурь болно гэж

ингээж миний хувьд үзэж байгаа юм. Үндсэн хуульд бол Цэцийн гишүүн болбол тавигдах шаардлага нь болбол юу гэхээр нөгөө улс төр, хууль, хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын иргэн 40 нас хүрсэн иргэн байна гээд ингээд заасан байгаа. Өнгөрсөн хугацаанд болбол маш их олон хүмүүс энэ Цэцийн суудлаар дамжиж ингээж явсан байдаг. Энэ дотор Монголын шилдэг хуульчид, улс төрчид энд орсон уу гэвэл одоо бас тийм биш л байгаа юм л даа. Шийдэж байгаа асуудлууд дээр нь болбол бас ард иргэдийн эргэлзээ, холбогдох байгууллагуудын эргэлзээнүүд энэ дээр их шүүмжлэлүүд их гардаг. Тийм учраас бол энэ Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг болбол маш өндөржүүлэх ёстой гэж. Монголын хамгийн сайн хуульч нар, хамгийн сайн эдийн засагч нар байх ёстой. Хуульч нар байхаас гадна энэ танхим дотор болбол бас нэг эдийн засагч нар баймаар байгаа юм.

Манайх шиг жижиг улсын хувьд болбол энэ эдийн засгийн харилцааныхаа юмыг ерөөсөө орхигдуулаад яваад байдаг. Цэцээр болбол эдийн засагтай холбоотой ийм асуудлууд их ордог. Тэгээд түүн дээрээ эдийн засгийн хүмүүс нь дорвитой юм хийгддэггүй. Хуваарилахдаа их шог хуваарилдаг. Эдийн засгийн харилцаатай холбоотой асуудлыг хуульчид өгчихдөг, хуульчдын юмыг эдийн засагчид өгчихдөг гэх мэтээр ийм юмнууд их явж байгаа юм л даа. Тэгэхээр эдгээрийг харгалзмаар байгаа юм 1 дүгээрт. 2 дугаарт энэ хуулийн төсөл дотор Цэцийн гишүүн нэр дэвшигчийг томилохдоо томилгооны сонсгол хийхээр оруулсан байгаа. Энэ зүйтэй, энийг бол дэмжиж байгаа. Цэц өөрөө 23 онд 5 дугаар дүгнэлт гэж гаргаад, бид томилгооны сонсгол хийхгүйгээр болно гээд өөрөө өөрсдийгөө хамгаалсан ийм юм гаргасан байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ заалт дээрээ бол хатуу зогсоод ингээд явах, цаашаа явах нь зүйтэй гэж ингээж үзэж байгаа юм.

Дараагийн асуудал бол юу вэ гэхээр Цэц бол 9 гишүүнтэй, төсөлд бол 7-гоос доошгүй гишүүн хүрэлцэн ирснээр



хүчинтэй болохоор тооцож байгаа юм. Цэц өнөөдөр 4 сар гаруй даргагүй байгаа, ямар ч асуудал авч хэлэлцээгүй. Энийг нэг талаас нь үзэх юм болбол энэ Цэцийн хямрал ч гэж үзэхээр ч болохоор. Даргаа сонгож чаддаггүй. Яагаад 9 хүн итгэл хүлээгээд тэнд очсон хүмүүс 9-үүлээ сууж байгаад даргаа сонгож болдоггүй юм бэ. Тэгээд 7 болгоод л ингээд доошоо ороод ирэхээрээ зэрэг энэ асуудлыг шийдэх гэж оруулж ирж байгаа юм уу, яаж байгаа юм бэ? Би болбол 9-үүлээ сууж байгаад шийдэх ёстой. 3 жилээр сонгоно, дахиад нэг удаа сунгаж болно гэж байгаа юм. Тийм учраас энэ жоохон буулт хийсэн энэ заалтаа эргээж үзвэл яасан юм бэ гэсэн ийм саналуудад саналуудыг хэлэх гэж байгаа. 9-үүлээ сууж байгаад тэгээд даргаа сонгох ёстой. Ямар нэгэн хүндэтгэх шалтгаан гарлаа гэж бодоход тэрийг бол өнөөдөр цахимаар өгч болно, тусгайлсан санал өгч болно. Ингэж байж тэр Цэцийг удирддаг хүмүүсийн тэр чадвар дээшлэх ийм л эрх зүйн орчин бүрдэх юм гэсэн ийм саналыг хэлэх гэж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг үг хэлье. Алтанхуяг гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд бариа эзлээрэй.

**Н.Алтанхуяг:** Энэ хуулийн төсөл дээр нэлээн сайн ажилласан хүн бол Мөнх-Оргил гишүүн л дээ. Тэгээд өөрийнх нь хэлээд байгаа нэг үг бол үнэн юм. Иргэн, иргэний үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн Цэцэд ярьдаг болъё. Энэ концепц бол одоо гарч босож ирнэ гэдэг бол хэцүү байсан. Энийг бол босгочихсон байгаа. Би бол зөв зүйтэй гэж байгаа юм. Тэгэхдээ өнөө өглөөнийхөө хурлыг хар даа, нэг цагийн дараа ирц чинь бүрдэж байна. Одоо энэ Их Хурлын танхимд сэтгэл зүрх нь уяатай ширхэг ч амьтан байхгүй, бүгдээрээ тойрог, ард түмэндээ хайртай, мөрийн хөтөлбөр 100 хувь биелсэн гэдэг юмаа яриад явж байгаа шүү дээ. Ийм үед ийм том концепталный асуудлыг энд ярьж болохгүй юм гэж би хэлж байгаа I.

2 дугаарт би өөрөө энийг дэмжиж орсон байхгүй юу Ажлын хэсэгт. Тэгээд энэ Цэцийн гишүүдтэй холбоотой сая Баттөмөр гишүүн ярьчихлаа. Тэрний 9 хүний тэрний хэрүүлгийг бид нар энэ ийм олон хуудас хуулиар зохицуулахгүй. Ер нь ч тэгээд одоо тэр нэг хэдэн хүн тэнд тавьж аваад, Үндсэн хуулийг сахиулж байх ёстой хүмүүс чинь одоо сүүлдээ, Цэц дээр асуудал байгаа юу гэвэл байгаа шүү дээ. Цэц болбол Үндсэн хуулийн манаач болох үүргээсээ умартсан. Энэ давхар дээлийг чинь тэд нар будилуулж хаясан биз дээ. Мааш олон асуудлыг болбол захиалгаар хийдэг болсон. Би бол Цэцтэй болбол асуудал ярих нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгэхдээ I хэдэн хүн алах гээд системээ устгаж болохгүй, ардчилсан тогтолцоогоо устгаж болохгүй. Одоо тийм юм руу явчихаад байна. Тийм учраас би санаа зовоод л хэлж байна л даа. Би одоо уг нь энэ чуулган завсарлахын хооронд үг хэлээд яах вэ гэж бас их бодсон юм. Үг хэлэхээр л өөдөөс ингээд л янз бүрийн юм хийгээд байдаг юм байна лээ. Яришигтай юм даа гэж бодсон чинь энэ ардчиллын үндсэн тогтолцоог ингэж эвдэж сүйдлэх эрхийг өгч болохгүй юм байна лээ шүү.

Дахиад төгсгөлд нь би нэг юм хэлье. Үндсэн хууль зөрчсөн хуулийг ярилцахад Улсын Их Хурлын гишүүн оролцохгүй байх эрхтэй юм байгаа юм. Би оролцохгүй, би дараа нь сугалж авна энийгээ. Сая Мөнх-Оргил гишүүнтэй ярихаар үгүй ээ, үгүй хэдүүлээ ингээд хэлэлцэх эсэхээ хэлэлцчихээд, тэгээд явцын дунд засчихъя л даа гэж. Юу хууль ийм ялгавартай байж болохгүй. Би энэ Улсын Их Хурлын Тамгын газрыг шүүмжилж байна. Би 34, нөгөө баялгийг ард түмэнд эзэмшүүлье гээд тогтоол оруулсан чинь миний тэрнийг юу гэж дүгнэсэн гээч эд нар Үндсэн хууль зөрчиж байна гэж солирсон шүү дээ. Үгүй ээ, тэгээд одоо энэ улаан цайм Үндсэн хууль зөрчихсөн хуулийн төсөл орж ирж байхад нь одоо ярьчихаад, одоо ярьчихаад, тэгээд дараагаар нь засчихъя, ийм байж болохгүй. Тийм учраас энэ Үндсэн хууль зөрчсөн энэ хуулийнхаа төслийг, би сая

*Мөнх-Оргил гишүүндээ зүгээр хэлсэн юм. Хуулийг ямар ч тохиолдолд татаад авчхаж болдог учраас татаад авчихвал яадаг юм бэ дээ. Би ер нь бол ерөнхийдөө энийг чинь цаашаа явуулахын төлөө шүү дээ. Тэгээд цаг үе чинь биш байна. Энийгээ авчхаач, далимдуулаад ингэчих.*

*Дахиад би Ардын намынхнаас нэг юм асуучихъя. Яг энэ Мөнх-Оргил гишүүн, нэг нь хэн билээ? Бямбацогт гишүүн 2-ын өргөн барьчхаад байгаа энэ хуулийн төсөл яг танай намын байр суурь юм уу? Дараа нь түүхэнд яаж бичигдээд байгаа вэ гэхээр үгүй тэр 3 нөхөр, 2 нөхөр л хууль батлуулчихсан юм байна лээ шүү дээ. Би прокурорын дэргэдэх мөрдөнг яриад байна шүү. Ингээд хариуцах эзэнгүй үлддэг. Засгийн газар оруулж ирж байгаа болбол бас нэг суугаад яримаар байна. Энэ нь тэгвэл энэ Засгийн газрын байр суурь, Ардчилсан намын 60 хэдэн хүний байр суурь гэвэл бас болно. Та нар энийгээ учраа ол дотроо. Би картаа сугаллаа. Үндсэн хууль зөрчсөн асуудлаар би оролцох боломжгүй.*

**Л.Мөнхбаатар:** *Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гишүүд байр сууриа илэрхийлж үг хэллээ. Дэмжсэн болон дэмжээгүй байр суурийг илэрхийлж үг хэллээ. Үндсэн хууль бол дээд хүчин чадалтай байх гол шинж нь бол Үндсэн хуулийн хяналт байдаг. Тийм учраас энэ Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох зорилгоор л энэ хууль санаачлан боловсруулагдсан гэж ойлгож байгаа. Хуулийн төслийг бол Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил, Бямбацогт нар санаачилсан. Сая энд бас дурдсанчлан зөвхөн 2 гишүүн санаачилсан учраас хэлэлцэх боломжгүй ч гэдэг юм уу ийм байр сууриуд бол зохимжгүй. Яагаад гэвэл хууль санаачлах эрх болбол нь Улсын Их Хурлын гишүүнд бий. Тийм учраас 2 биш, 1 гишүүн ч санаачилж болно. Харин хэлэлцүүлэг бол өргөн хүрээнд өрнөх ёстой. Түрүүн бас Ганбат гишүүн байр сууриа илэрхийлж хэлж байгаа бол үнэн. Олон талын оролцоог хамруулсан, нам эвслийн бүлгүүд, Улсын Их Хурлын бүтцийн байгууллагуудаараа бүгдийг нь*

*оролцуулсан, эрдэмтэн судлаачдын байр суурийг хамтатган хэлэлцүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ хуулийг бол эцэслэн шийдвэрлэх учиртай.*

*Тэгэхийн тулд хуулийн төслийн одоо хэлэлцэх эсэхийг шийдээд, хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа ажлын хэсэг гарч энэ асуудлуудыг олон талаас нь нухацтай авч үзэж, хэлэлцэх нь бол зүйтэй гэдэг гишүүдийн байр суурьтай санал нэг байгаа юм. Ийм учраас одоо санал хураалтыг явуулна. Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд байраа эзэлье, санал хураалт явагдана. Байнгын хорооны саналаар, Улсын Их Хурлын гишүүд байраа эзэлье. Мөнх-Оргил гишүүн хүрээд ирээч. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана. Гишүүд суудлаа эзэлье. Гишүүд суудлаа эзлээрэй.*

*Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай шинэчилсэн найруулга хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны*

тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Гэхдээ энийг энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь хэдийгээр шийдсэн ч гэсэн цаашид энэ хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд бас маргаантай зүйлүүд бас яригдаж байгаа. Ардчилсан намын бүлэгтэй бас ярилцах шаардлагууд байна. Энэ хуулийн төслийг нам, эвслийн бүлгүүд, Их Хурлын бүтцийн байгууллагууд бол бас санал нэгдэж хэлэлцэх ёстой ийм чухал томоохон хууль байгаа. Тийм учраас энэ олон талаас нь бас ярих ёстой гэдгийг бас энд хэлэх нь зүйтэй гэж бодож бодож байна.

11.58 цаг

**Хоёр. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Ингээд дараагийнхаа асуудалд оруулъя, оръё. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Энэ асуудлаар 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл 5 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Ингээд асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье. Гишүүд асуулт

асууж, хариулт авч дууссан. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга байна.

Байнгын хорооны саналаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд. 70,3 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

12.00 цаг

**Гурав. “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Дараагийнхаа асуудалд оръё. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Хууль зүйн

байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцлээ.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасныг баримтлан Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Тогтоолын төсөлд Монгол Улсын олон талт олон улсын гэрээтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж өргөн мэдүүлэх, олон улсын, Монгол Улсын олон талт олон улсын гэрээ болон холбогдох тайлбаруудыг орчуулж, хэвлэн нийтлэх, олон улсын гэрээний хэрэгжилт хариуцсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, олон улсын гэрээний талаарх иргэдийн боловсролыг дээшлүүлэх, олон улсын гэрээний зүйл, заалтын практик хэрэглээг бий болгох, хэрэгжилт, хариуцах төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл дамжуулах, солилцох цахим мэдээллийн санг бий болгохыг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын үйл явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлттэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Мөнхбаатар:** Энх-Амгалан гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх хүн байна уу? Байхгүй байна. Ганбат гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Энэ олон улсын гэрээ конвенцод нэгдэх энэ бас их чухал асуудал. Энэ гэрээ конвенц энэ бүх юманд нэгдчихээр энэ чинь яг л манай дотоодын хууль тогтоомж шиг манай улс оронд үйлчилдэг гэж ойлгож байгаа. Энэ ойлголт нэг байна уу гэдгийг тодруулъя.



Нөгөө талаар олон улсын зээл тусламж бид нар авч байгаа, маш чанартай сайхан зээл тусламж үзүүлдэг газрууд бол дандаа ийм хөгжсөн орнууд байдаг, ардчилалтай. Бид нар маш хүнд хэцүү үед бол тэр Японы зээл тусламжийг бид нар их санаж байна. Тэр хуурай сүү, тэр цэнхэр автобус. Энэ бүхэн бол манай ард түмний сэтгэлд их үлдсэн.

Нөгөө талаар бол энэ ковидын үед ч гэсэн бас тэр КОВАКС хөтөлбөрт хамрагдаад, тэр чанартай сайн вакциныг бол бас Японы Засгийн газар, Японы ард түмнээс тусламж үзүүлж байсан. Бид бүхэн бол хуучин бол социализм байгуулах гээд л ярьдаг байсан, их олон сайхан үйлдвэр заводуудыг бол манай тэр социалист системийн хамт байсан гадна, дотнын улс орнууд байгуулж өгсөн гэдгийг бид бүхэн мэдэж байгаа. Саяхан ч гэсэн одоо тэр Замын-Үүдийн хилийн боомтын юуг бол Хятадын Засгийн газрын тусламж, Хятадын ард түмний бас одоо буцалтгүй тусламжийн хүрээнд бол 290 тэрбум төгрөг тэднийх гаргаад, манайх 10 хэдэн тэрбум төгрөг гаргаад хийсэн гэж ойлгож байгаа. Тэгээд бид нар ингээд баярлалаа гэдгээ хэлэхгүй юм. Энэ Засгийн газар, энэ Монгол Ардын нам. Энийгээ хэлж байгаа юу, хэлэхгүй байгаа юу? Дахин, дахин л баярлалаа гэдгээ хэлж байх ёстой. Өөрсдөө гийгүүлээд байгаа юм байхгүй мөртөө тэгээд гадна, дотнын тусламжаар олсон юмаа бас тэрийг нь ил тод зарлаад, ард түмэнд сайхан ойлгуулаад ингэж явбал дараа дараагийн тусламж чинь ирэх юм чинь илүү л сайн нээгдэнэ шүү дээ. Энийг бас анхааруулчихъя. Энэ дээр ямар байгаа билээ?

Нөгөө талаар бол манай түрүүчээсээ олон улсын байгууллагад манай бас хүмүүс ажиллаад эхэлчихсэн байна их сайн. Тухайлбал Гаагийн шүүхэд эрүүгийн шүүхэд бол манай шүүгч нар очоод эхнээсээ ажиллаж байна. Нөгөө талаар бол энэ Гаагаас энэ олон улсын байгууллагаас гарсан энэ хууль тогтоомжийг бид нар хэр мөрддөг юм бэ? Тухайлбал, Оросын Холбооны улсын

Ерөнхийлөгч ахиад сонгогдлоо л доо сая. Ноён Путин бол тэндээс дайны гэмт хэрэгтэн гээд зарлачихсан байгаа. Энэ хүнийг одоо ямар нэгэн газар явбал бид нар барьж өгөх үүрэгтэй юу, үүрэггүй юу? Энэ хууль чинь конвенц энэ тэр нь манай дээр нөлөөлдөг юм уу, үйлчилдэг юм уу, үйлчилдэггүй юм уу? Энийг бас би нэг тодруулмаар байх юм. Тэгээд яг яах ёстой юм бэ тэр конвенцоороо? Яах вэ тэр Украины хүүхдүүдийг хулгайлсан гэдгийг бол гэмт хэрэг гэж зарлаад, тэр нэг авгай нөгөө Владимир Владимирович 2-ыг, Путин 2-ыг бол одоо цэргийн гэмт хэрэгтэн гээд зарлачихсан байгаа дайны. Үгүй ээ, тэгээд манайд айлчилж ирж таараа л даа. Тийм. 2 хөрш оронтойгоо бид нар маш найрсаг сайхан хамт хамтарч ажиллах ёстой. Энэ хууль ном нь яг ямар байна вэ, үйлчилдэг юм уу, үйлчилдэггүй юм уу? Бас эндээ одоо бас аятайхан болгоомжтой хандахгүй бол дараа нь бас эвгүй байдалд орох вий гэсэн ийм хэдэн асуултууд байх юм. Та нар маань бас юм бодож л байдаг байлгүй дээ. Энийг нэг тодруулж өгөөч.

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Цэндийн Мөнх-Оргил хариулъя. Мөнх-Оргил, Байнгын хорооны дарга хариулах юм уу, хэн нь хариулах юм бэ? Ажлын хэсгийн дарга Цэндийн Мөнх-Оргил хариулъя. Нэмээд Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар нэмж хариулж болно.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Би ажлын хэсгийнхээ бэлдсэн тогтоол, тогтоолын хавсралтын хүрээнд л ярьж тэгэх үү Ганбат гишүүнээ, тэрэнд л тэрэнтэй холбоотой асуултад л хариулъя. Өөрөөр хэлбэл 1 дүгээр асуулт энэ олон улсын гэрээ конвенцод соёрхон батлаад нэгдэн ормогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна уу? Тэгэж үйлчилж байгаа болохоор л та нар маань ажлын хэсэг байгуулаад одоо энэний үйл ажиллагаа, энэ гэрээний хэрэгжилтийг шалгаад байна уу гэж асуулаа шүү дээ тийм ээ. Энэ тийм. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-д

ингээд биччихсэн байгаа юм. Монгол Улсын, тунхагласан байгаа юм. Монгол Улсын олон улсын гэрээнд соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гээд заачихсан. Энэ заалт тэр болгон бас хэрэгжилт хангалтгүй байгаа юм, хангалтгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, зарим олон улсын гэрээг соёрхон батлаад, тэрийг хэрэгжүүлэхийн тулд дотоодын хууль тогтоомжид шууд суулгаж байх ёстой гэрээнүүд байгаа юм. Зарим нь болохоор дотоодын хууль тогтоомжид суулгах шаардлагагүйгээр өөрөө байгаа текстээрээ шууд хэрэгжиж байх ёстой юм байгаа юм. Энэ дээр бид нар Байнгын хороон дээр ярьсан. Техникийн болон одоо юу гэдэг юм орчуулгын хүндрэлүүд гараад байгаа юм.

Манай шүүх Шүүхийн хуулиараа Монгол Улсын соёрхон баталсан, нэгдэн орсон, гэхдээ албан ёсоор орчуулагдаж, албан ёсоор Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэн хуулийг л хэрэглэх ёстой юм хуулиараа. Тэгээд тэр хуулийнхаа заалтыг бариад, нөгөө нийтлэхийг нь хүлээгээд байдаг, орчуулахыг нь хүлээгээд байдаг. Гэтэл Монгол Улс чинь жишээ нь зөвхөн олон талт гэрээ конвенц гэхэд 225 гэрээ конвенц нэгдээд орчихоод байгаа байхгүй юу. Тэгээд их том, том зузаан, зузаан материалууд, том, том зузаан текстүүд. Тэгээд тэр орчуулга дээр, хэвлэх асуудал дээр жоохон хоцрогдох тал гараад байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт энэ нэгдээж орсон гэрээ конвенцыг энэ манай төрийн захиргааны шүүх, хууль хяналтын байгууллагын ажилтнуудад ойлгуулах, сургах, сурталчлах ажил жоохон хоцрогдож яваад байгаа юм. Энэ дээр анхаарах хэрэгтэй байгаа юм. Тэр олон улсын шүүхийн асуудлыг бол та шүүхийнхнээс юм уу, тэр Гаагийнхнаас л асуух байх даа. Манай ажлын хэсэг бол энэ асуудлыг яриагүй, авч хэлэлцээгүй.

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүн тодруулах юм уу? Ганбат гишүүн тодруулж асууя, 1 минут.

**Д.Ганбат:** Ингээд уул нь би асуулт асуугаад, ингээд хариулт авах ийм бүрэн эрхтэй л дээ. Тэгээд яах вэ Мөнх-Оргил гишүүн маань л бас нэг жоохон дөхүүлж хариулах юм. Энэ гишүүдийн жоохон чанарыг жоохон сайжруулмаар байна, энэ дарга нарын тийм. Дараа дараагийн нэр дэвшилт дээр энэ Монгол Ардын нам боловсон хүчний асар их нөөцтэй гээд байгаа тийм. Энэ дээрээ анхаармаар байна. Тэгээд би энэ гадна, дотнын юмыг би юу гэж Гаагийн шүүхээс асуух вэ. Би Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болж магадгүй, болзошгүй ийм зүйлийг асууж байна.

Ер нь та нар ган, зудад бэлтгэлгүй байсан шигээ ер нь ямар ч асуудалд бэлтгэлгүй юм. Тэгсэн мөртөө нэг л дарга сайд болох дуртай улсууд, ийм байх юм нөхдүүд минь. Тэгээд энийг чинь одоо ард түмэн хараад сууж байгаа шүү дээ бас. Эд нар маань ямар байна вэ, тэгээд яг тийм ийм гээд зоригтой хариулчих ч хүн ч байхгүй, яах нь ч мэдэгдэхгүй. Тэгээд хөрсүүдээ эвгүй байдалд.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүн байр сууриа илэрхийлж үг хэллээ. Тодорхой асуулт алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүдээ. Та яах юм бэ, горимын санал авах юм уу? Энэ алга байна шүү дээ. Санал хураалт явуулна, гишүүд байраа эзлээрэй. Байнгын хорооны санал, дүгнэлтийг аваад ир дээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар бол заавал горимын санал гаргахгүй. Байнгын хорооны саналаар санал хураачихсан учраас одоо энийг баталъя гэсэн



*томъёоллоороо шууд явчих юм байна.  
Гишүүд болсон уу, байраа эзэлсэн үү?  
Санал хураалт гишүүд. 63,2 хувиар санал  
дэмжигдлээ. Тогтоолын төсөл  
батлагдлаа.*

*12.14 цаг*

*Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар  
хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы  
нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.  
Даргын зөвлөл одоо манай өрөөнд  
хуралдана. Даргын зөвлөлийн гишүүд  
хуралдаандаа орохыг хүсье.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

